



ШҮҮХИЙН АКАДЕМИ



МОНГОЛ УЛСЫН ИХ
СУРГУУЛИЙН ХУУЛЬ ЗҮЙН
СУРГУУЛЬ



ХУУЛЬ ЗҮЙН ҮНДЭСНИЙ
ХҮРЭЭЛЭН

ЭШЛЭЛ ХИЙХ, ЭХ СУРВАЛЖИЙГ ЗААХ, НОМ ЗҮЙН БИЧИЛТ ХИЙХ СТАНДАРТ

1. Хамрах хүрээ

Энэхүү стандарт нь Улсын дээд шүүхийн дэргэдэх Шүүхийн сургалт, судалгаа, мэдээллийн академийн хийж гүйцэтгэж буй эрдэм шинжилгээ, судалгааны ажлуудад эшлэл хийх, эх сурвалжийг заах, ном зүйн бичилт хийх шаардлагыг тогтооно.

2. Нэр томьёо

Эшлэл: Бусад бүтээлд дурдагдсан мэдээлэл болон санааг шууд болон шууд бусаар эш татан хэрэглэхийг ойлгоно.

Бичвэрт заагдсан эх сурвалж: Үндсэн бичвэрт эш татсан тухайн хэсэгтээ эшлэлийн эх сурвалжийг хаалтад дурдаж оруулахыг ойлгоно.

Зүүлт тайлбар (footnote)-т заагдсан эх сурвалж: Шууд болон шууд бусаар эшилсэн эх сурвалжаа зүүлт тайлбар хэсэгт дурдаж оруулахыг ойлгоно.

Ном зүй: Эшлэлд дурдагдсан болон тухайн судалгааны ажилд ашигласан ном, сурах бичиг, судалгааны тайлан, орчуулгын бүтээл, эрдмийн зэрэг горилсон бүтээл, өгүүлэл, илтгэл, нийтлэл, эрх зүйн баримт бичиг, цахим орчин дахь мэдээлэл зэрэг бүх төрлийн эх сурвалжийг ойлгоно.

3. Ерөнхий шаардлага

3.1. Шууд эшлэл: Эшлэл нь 40-өөс доошгүй үгтэй тохиолдолд шууд эшлэл авч болох бөгөөд эшилж авсан хэсэг, санаа, нэр томьёог “ ” хашилтад хийж өөрийн бичвэрээс зааглана.

3.2. Шууд эшлэл нь 40-өөс дээш үгтэй бол хашилтад хийхгүй бөгөөд эшилсэн хэсгийг бүхэлд нь зүүн гар талаас догол мөр үүсгэн тусгайлан бичнэ.

3.3. Шууд болон шууд бус эшлэл хийх тохиолдолд эх сурвалжийг тухайн эшлэлийн ард хаалт нээж дурдах эсхүл зүүлт тайлбар /footnote/ хэсэгт дурдах төдийгүй “ном зүй” хэсгийн жагсаалтад оруулна.

3.4. Мөн зүүлт тайлбар /footnote/-ыг үгийн тайлбар, нэмэлт тайлбар, залруулга, нэмж судлах материалуудын талаарх мэдээлэл өгөх тохиолдолд хэрэглэж болно.

3.5. Шууд болон шууд бусаар эшилж байгаа хэсгээс гол санааг тодруулах, өөр форматаар өөрчилж бичих тохиолдолд “Судлаачийн зүгээс зарим хэсгийг тодруулсан болно.” гэж зүүлт тайлбар хэсэгт бичнэ.

3.6. Үндсэн эшлэл нь бүтэн биш бол дутуу хэсэгт нь (...) гэж 3 цэг бичнэ.

3.7. Он бичих тохиолдолд зүүлт тайлбар /footnote/ хэсэгт (2023) гэх мэт он гэсэн үггүй байх бөгөөд ном зүйн хэсэгт “он” гэдэг үгтэй бичнэ.

3.8. Сар, өдөр бичих тохиолдолд 05, 07 гэх мэт 0-ийн тоотой бичнэ.

3.9. Хуудас бичих тохиолдолд “дахь тал, дэх тал, дох тал” гэж бичнэ.

3.10. Монгол Улсын хууль эшлэхэд “Төрийн мэдээлэл” эмхэтгэлд нийтлэгдсэн дугаарыг, Төрийн мэдээлэлд нийтлэгдээгүй тохиолдолд “Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем”-д нийтлэгдсэн холбоосыг бичнэ.

4. Бичвэр дотор эх сурвалжийг заах

Бичвэр дотор эх сурвалжийг дурдахдаа *Хавсралт 1*-д заасны дагуу бичих бөгөөд зохиогч болон хэвлэгдсэн он, хуудасны дугаарыг заана.

5. Зүүлт тайлбарт эх сурвалжийг заах

5.1. Зүүлт тайлбарт эх сурвалжийг заахдаа *Хавсралт 2*-т заасан загварыг баримтална. Гадаад хэлээс эшлэл аван зүүлт тайлбар хэсэгт эх сурвалжийг дурдах тохиолдолд *Хавсралт 4*-ийг мөрдөнө.

5.2. Өмнө эшилсэн эх сурвалжийг дахин эшлэх тохиолдолд “*өмнөх эшлэл*” гэж бичиж өмнөх эшлэлийн дугаар, эх сурвалжийн хуудасны дугаарыг бичнэ.

5.3. Нэг эх сурвалжийн ижил хуудсыг дараалан эшлэх тохиолдолд сүүлд эшилснийг “*мөн тэнд*” гэж бичнэ.

5.4. Дам эшлэхэд “*дам эшлэл*.” гэж бичиж, эшилсэн эх сурвалжийг бичнэ.

5.5. Цахим эх сурвалжаас эшлэл авах тохиолдолд холбоосыг налуу (*italic*) хэлбэртэй бичих бөгөөд сүүлд үзсэн он, сар, өдрийг (Сүүлд үзсэн:) гэж хаалтад хийж бичнэ. Үүнд legalinfo хамаарахгүй болно.

6. Ном зүйд эх сурвалжийг заах

6.1. Ном зүйд эх сурвалжийг бичихдээ *Хавсралт 3*-т заасан загварыг баримтална.

6.2. “НОМ ЗҮЙ”-г судалгааны ажлын төгсгөл хэсэгт тухайн хэлний цагаан толгойн үсгийн дарааллаар, дугаарлаж бичнэ.

6.3. Ном зүй нь “Монгол хэл дээрх эх сурвалж”, “Гадаад хэл дээрх эх сурвалж” “Цахим эх сурвалж” гэсэн хэсэгтэй байна.

Монгол хэл дээрх эх сурвалжийг бичихдээ “Эрх зүйн эх сурвалж”; “Ном, сурах бичиг”; “Эрдэм шинжилгээний бүтээл”; “Бусад” гэсэн хэсэгт ангилж бичнэ.

Гадаад хэл дээрх эх сурвалжийг бичихдээ улсын нэрийг цагаан толгойн үсгийн дарааллаар дараалуулж, тухайн хэл дээрх эх сурвалжийг жагсаан бичнэ.

Цахим эх сурвалж хэсэгт мэдээллийг олж авсан цахим хуудасны хаягийг бичих бөгөөд дэлгэрэнгүй холбоос болон сүүлд үзсэн он, сар, өдөр зэргийг бичихгүй. Харин тухайн хуудасны нэрийг бичнэ. Жишээ нь: Эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: www.legalinfo.mn гэх мэт. Гадаад улсын цахим хуудсыг монгол хэл рүү орчуулж бичнэ. Жишээ нь: Канад улсын дээд шүүхийн цахим хуудас: <https://www.scc-csc.ca/> гэх мэт.

6.4. Ном зүйн жагсаалт бичихдээ цагаан толгойн үсгийн дарааллыг баримтлах бөгөөд дараах зүйлийг анхаарвал зохино.

6.4.1. Нэг зохиогчийн хэд хэдэн бүтээлийг ном зүйд цаг хугацааны дарааллын дагуу бичнэ.

6.4.2. Олон зохиогчтой эх сурвалжийн зохиогч тус бүрийг дурдах ба тухайн бүтээлд хэвлэгдсэн хамгийн эхний зохиогчийн нэрийг баримтлан дараалуулна.

6.4.3. Зохиогчгүй, эмхэтгэгч, редактортай бүтээлийг ном зүйд оруулахдаа редакторын нэрийг дээрх зарчмаар дараалуулна.

6.4.4. Зохиогч, эмхэтгэгчгүй бол эрхлэн гаргасан байгууллагын нэрийг бүтнээр нь оруулах ба нэрийн эхний үсгийг цагаан толгойн үсгийн дарааллаар дараалуулна.

6.4.5. Хичээл, хурлын тэмдэглэл, радио, телевизийн нэвтрүүлэг, ярилцлага зэрэгт тухайн ярилцлага өгсөн хүний нэрийг, ярилцлага өгсөн хүний нэр тодорхойгүй тохиолдолд хурал, нэвтрүүлэг зэрэг үйл ажиллагааны нэр хаягийн эхний үсгээр дараалуулна.

ХАВСРАЛТ 1. ЭХ БИЧВЭР ДОТОР ЭХ СУРВАЛЖИЙГ ДУРДАХ ЖИШЭЭ

Нэг зохиогчийн бүтээл	Загвар: Зохиогчийн нэрийг өгүүлбэрт дурдаагүй тохиолдолд хаалтад зохиогчийн, нэр, он, хуудасны дугаарыг бичнэ.
	Жишээ: Манайд бол “төр”, “улс” гэсэн хоёр үг хууль зүйн нэр томъёоны хувьд нэгэн адил утга, багтаамжтай гэж болно (Б.Чимид, 1989, 1 дэх тал).
	Загвар: Зохиогчийн нэрийг өгүүлбэрт оруулсан бол хаалтад дахин зохиогчийн нэрийг нь дурдалгүйгээр зөвхөн он, хуудасны дугаарыг бичнэ.
	Жишээ: Б.Чимид (1989, 1 дэх тал) “төр”, “улс” гэсэн хоёр үг хууль зүйн ...
Олон зохиогчтой бүтээл	Загвар: 2 зохиогчтой бүтээлээс эшилсэн бол эшлэх тохиолдол бүрд 2 зохиогчийн нэрийг хамтад нь дурдана.
	Жишээ: Судлаачид (Б.Чимид, Г.Совд, 1993, 56 дахь тал) энэ тухайд ...
	Загвар: 2-5 зохиогчтой бүтээлээс эш татвал хамгийн эхний эшлэлийн тайлбарт бүх зохиогчийн нэрийг бичээд дараа нь тэр бүтээлээс дахин эш татсан тохиолдолд зөвхөн эхний зохиогчийн нэрийг дурдаад бусад зохиогчийн нэрийг бичилгүй “бусад” гэж товчилно.
	Жишээ: <i>Эхний эшлэлд:</i> (Б.Чимид, Г.Совд, С.Нарангэрэл, 1996, 32 дахь тал) <i>Дараагийн эшлэлүүд:</i> (Б.Чимид ба бусад, 1996, 32 дахь тал)
Байгууллагаас эрхлэн гаргасан ном	Загвар: Байгууллагын нэр, он, хуудасны дугаар
	Жишээ: (Нээлттэй Нийгэм Форум, 2004, 26 дахь тал)
Сэтгүүлийн өгүүлэл	Загвар: Зохиогчийн овгийн эхний үсэг. Нэр, он, хуудасны дугаар
	Жишээ: (Д.Сүнжид, 2022, 10 дахь тал)
Зохиогч нь тодорхойгүй	Загвар: Зохиогч нь тодорхойгүй үед тухайн өгүүллийн гарчиг эсхүл бүлгийн нэр, веб хуудсыг (“”) хашилтад бичнэ.

үед	<i>Жишээ:</i> (“Эвслийн засгийн газруудын эргэж задарсан түүх”, 2015) (“politics.news.mn”, 2015)
Зохиогч нь тодорхойгүй бөгөөд тогтмол хэвлэл	<i>Загвар:</i> Зохиогч нь тодорхойгүй бөгөөд тогтмол хэвлэл, ном, товхимол болон тайлангийн нэрийг налуу (<i>Italic</i>) хэлбэрт оруулан бичнэ.
	<i>Жишээ:</i> (Монголын мэдээ, 2011)
Хүний хэлсэн үг	<i>Загвар:</i> “” хашилтад хийж, налуу (<i>italic</i>) хэлбэртэй бичнэ.
	<i>Жишээ:</i> “Хуульч хүн жинхэнэ хүн байх ёстой”
Хуулийн заалт	<i>Загвар:</i> Хууль, хуулийн заалтын дугаар, хуулийн заалтыг “” хашилтад хийж, налуу (<i>italic</i>) хэлбэртэй бичнэ.
	<i>Жишээ:</i> Иргэний хуулийн 25 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт “Хуулийн этгээд нь нийтийн, хувийн, холимог өмчийн байна.”

ХАВСРАЛТ 2. ЗҮҮЛТ ТАЙЛБАР ХЭСЭГТ ЭХ СУРВАЛЖИЙГ ДУРДАХ ЖИШЭЭ

А. НОМ

Нэг зохиогчтой ном	Загвар: Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>Бүтээлийн нэр</i> , (хаалтад хэвлэгдсэн хот: хэвлэсэн газар, хэвлэгдсэн он), хуудасны дугаар.
	Жишээ: Нанзаддоржийн Лүндэндорж, <i>Шилжилтийн үе: улс төр, эрх зүйн асуудал</i> , (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2010), 19 дэх тал.
Хоёр зохиогчтой ном	Загвар: Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>Бүтээлийн нэр</i> (хэвлэлтийн дугаар), (хаалтад хэвлэгдсэн хот: хэвлэсэн газар: хэвлэгдсэн он), хуудасны дугаар.
	Жишээ: Батын Баярдаваа, Доржийн Гансүлд, <i>Макроэкономикс</i> (2 дахь хэвлэл), (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2006), 6 дахь тал.
Гурваас таван зохиогчтой ном	Загвар: Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, хоёр дахь, гурав дахь, дөрөв дэх Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>Бүтээлийн нэр</i> (хэвлэлтийн дугаар), (хаалтад хэвлэгдсэн хот: хэвлэсэн газар, хэвлэгдсэн он), хуудасны дугаар.
	Жишээ: Батын Дэлгэрмаа, Доржийн Оюун, Жаргалын Хулан, <i>Бизнесийн эрх зүй</i> (2 дахь хэвлэл), (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2010), 80-83 дахь тал.
Зохиогч тодорхойгүй, нэг редактортай ном	Загвар: Редакторын овог (бүтнээр). Нэр (Ред), <i>Бүтээлийн нэр</i> (хэвлэлтийн дугаар), (хаалтад хэвлэгдсэн хот: хэвлэсэн газар, хэвлэгдсэн он), хуудасны дугаар.
	Жишээ: Цэндийн Содов (Ред), <i>Боловсрол судлалын үндэс</i> (2 дахь хэвлэл), (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2009), 10 дахь тал.
Зохиогч тодорхойгүй, хоёр редактортай ном	Загвар: Редакторын овог (бүтнээр). Нэр, хоёр дахь редакторын овог (бүтнээр). Нэр (Ред), <i>Бүтээлийн нэр</i> (хэвлэлтийн дугаар), (хаалтад хэвлэгдсэн хот: хэвлэсэн газар, хэвлэгдсэн он), хуудасны дугаар.
	Жишээ: Бяраагийн Чимид, Цэндийн Содов (Ред), <i>Боловсрол судлалын үндэс</i> (2 дахь хэвлэл), (Улаанбаатар: Адмон, хэвлэлийн компани, 2009), 10 дахь тал.
Байгууллагаас	Загвар:

эрхлэн гаргасан ном	Эрхлэн гаргасан байгууллагын нэр, <i>Бүтээлийн нэр (хэвлэлтийн дугаар)</i> , хэвлэгдсэн он, хуудасны дугаар.
	<i>Жишээ:</i> Нээлттэй нийгэм форум, <i>Төрийн бус байгууллага ба татвар (2 дахь хэвлэл)</i> , 2004, 5 дахь тал.

Б. ӨГҮҮЛЭЛ

Нэг зохиогчтой өгүүлэл	<i>Загвар:</i> Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, “Өгүүллийн нэр”, <i>Сэтгүүлийн нэр, Сэтгүүл гаралтын дугаар</i> , (тухайн оны дугаар), он, хуудасны дугаар.
	<i>Жишээ:</i> Одонхүүгийн Мөнхсайхан, “Монгол Улс дахь засгийн газрыг эмхлэн байгуулах ажиллагааг боловсронгуй болгох нь”, <i>Хууль дээдлэх ёс</i> 51 (1), 2015, 55-66 дахь тал.
Хоёр зохиогчтой өгүүлэл	<i>Загвар:</i> Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, Хоёр дахь зохиогчийн овог (бүтнээр). Нэр, “Өгүүллийн нэр”, <i>Сэтгүүлийн нэр, Сэтгүүл гаралтын дугаар</i> (тухайн оны дугаар), он, хуудасны дугаар.
	<i>Жишээ:</i> Болдын Амарбаясгалан, Тэрбишийн Мөнх-эрдэнэ, “Шүүхийн ил тод байдал: шүүгчийн тусгай санал ба саналын тооны харьцааг нийтлэх шаардлага”, <i>Монголын төр, эрх зүй</i> 104 (2), 2023, 6 дахь тал.
Цахим хуудас дахь өгүүлэл	<i>Загвар:</i> Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, “Өгүүллийн нэр”, <i>цахим хуудасны хаяг</i> , Өгүүлэл бичигдсэн он, хуудасны дугаар, (Сүүлд үзсэн: он.сар.өдөр)
	<i>Жишээ:</i> Цэндийн Цогт, “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ”, <i>legaldata.mn</i> , 2023, 11 дэх тал, (Сүүлд үзсэн: 2024.08.15)

В. БУСАД

Докторын диссертац	<i>Загвар:</i> Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>Диссертацийн нэр</i> , Эрдмийн зэрэг, он, хуудасны дугаар.
	<i>Жишээ:</i> Пүрэвээгийн Гантөмөр, <i>Эдийн засгийн өсөлтөд нөлөөлөгч зарим хүчин зүйлсийн шинжилгээ</i> , Эдийн засгийн ухааны докторын диссертац, 2015, 150 дахь тал.
Магистрын диссертац	<i>Загвар:</i> Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>Диссертацийн нэр</i> , Эрдмийн

	зэрэг, он, хуудасны дугаар.
	Лхагвасүрэнгийн Галбадар, Эрүүгийн хуулийн тайлбар: Онол, арга зүйн зарим асуудал , Хууль зүйн магистрын диссертац, 2015, 15 дахь тал.
Илтгэл	Загвар: Илтгэгчийн овог (бүтнээр). Нэр, “Илтгэлийн нэр”, <i>Хурлын нэр</i> , (хурал болсон он, сар өдөр), Хурал болсон хот, Улс.
	Хэрэв илтгэлийг цахим эх сурвалжаас авсан бол: Илтгэгчийн овог (бүтнээр). Нэр, “Илтгэлийн нэр”, <i>Хурлын нэр</i> , (хурал болсон он, сар өдөр), Хурал болсон хот, Улс, <i>Цахим хуудас</i> .
	Жишээ: Цэрэнбалтавын Сарантуяа, “Үндсэн хуулийн маргаан шийдвэрлэх ажиллагааны зарим асуудал”, <i>Үндсэн хуулийн болон захиргааны эрх зүйн үндсэн асуудал: хямралын үеийн тулгамдсан асуудал олон улсын эрдэм шинжилгээний 3 хурал</i> , (2021.11.20), Улаанбаатар хот, Монгол улс.
Хурал, хэлэлцүүлгийн тэмдэглэл	Загвар: Хурал, хэлэлцүүлэг зохион байгуулсан газар, “Хурал, хэлэлцүүлгийн нэр”, хурал, хэлэлцүүлэг болсон он сар өдөр, <i>цахим хуудас</i> , (Сүүлд үзсэн: он.сар.өдөр).
	Жишээ: “УИХ-ын ТББХ, УИХ-ын ээлжит чуулганы Төрийн байгуулалтын байнгын хорооны хуралдааны тэмдэглэл”, 2017.10.26, https://www.parliament.mn/nn/1102/ , (Сүүлд үзсэн: 2023.05.03).
Цахим хуудасны мэдээ, пост (зохиогч нь тодорхойгүй бол)	Загвар: “Мэдээний гарчиг”, Мэдээ нийтлэгдсэн он, <i>цахим хуудас</i> , (Сүүлд үзсэн: он.сар.өдөр).
	Жишээ: “Эвслийн засгийн газруудын эргэж задарсан түүх”, 2020, http://politics.news.mn/content/127486.shtml , (Сүүлд үзсэн: 2015.03.21).
Сонин	Загвар: Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, “Өгүүллийн нэр”, Сонины нэр, дугаар, (хэвлэгдсэн он, сар,өдөр), хуудасны дугаар.
	Жишээ: Хорлоогийн Батсайхан, “Алтны хани галзуурсан нь цөвүүн цагийн дохио юу”, Монголын мэдээ, №090(3175), (2011.05.06), 10 дахь тал.
Орчуулгын бүтээл	Ном эшлэх загвар: Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>Бүтээлийн нэр</i> , (Орч Орчуулагчийн овог (бүтнээр). Нэр), хэвлэгдсэн он, хуудасны

	дугаар.
	Жишээ: Жан Жак Руссо, <i>Нийгмийн гэрээ</i> , (орч Цэндийн Батбуян), 2016, 15 дахь тал
	Өгүүлэл эшлэх загвар: Зохиогчийн овог (бүтнээр), Нэр “Бүтээлийн нэр”, (Орч Орчуулагчийн овог (бүтнээр). Нэр), он, хуудасны дугаар, <i>цахим хуудас</i> , (Сүүлд үзсэн он сар өдөр).
	Жишээ: Гuido Калабреси, Спенсер Смит, “Гэм хорын эрх зүй дэх дуализм”, (Орч Сайнтөрийн Цэрэндолгор), 2022, 10 дахь тал, www.legaldata.mn (Сүүлд үзсэн: 2015.03.21).
Тайлан	Загвар: Тайлан гаргасан байгууллагын нэр, “Тайлангийн нэр”, Тайлан гаргасан он сар өдөр. Хэрэв тайланг цахим эх сурвалжаас авсан бол цахим хуудсыг бичнэ.
	Жишээ: Шүүхийн ерөнхий зөвлөл, “Монгол улсын шүүхийн 2023 оны бүтэн жилийн шүүн таслах ажиллагааны нэгдсэн дүн мэдээ”, 2024, www.judcouncil.mn .
Подкаст, ярилцлага	Загвар: Эрхлэн гаргасан газар, Зочны овог (бүтнээр), Нэр, “Подкастын гарчиг”, Подкастын нэр, он сар өдөр, <i>цахим хуудас</i> .
	Жишээ: Хууль зүйн үндэсний хүрээлэн, Түмэнжаргалын Мэндсайхан, “Эрх зүйн актын системчлэл”, Хуулийг энгийнээр подкаст, 2024.04.01, https://www.youtube.com/watch?v=ZN8JB2uVVdY
Видео, youtube дээрх дүрс бичлэг	Загвар: Эрхлэн гаргасан газар, Дүрс бичлэгийн гарчиг, “Контентын нэр”, Дугаар, Он сар өдөр, <i>Цахим хуудас</i>
	Жишээ: Монголын Шүүгчдийн Холбоо, “Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх ажиллагаа”, Ярьж буй хууль №35, www.youtube.com .
Дам эшлэл	Загвар: <i>Дам эшлэв:</i> гэж налуу (<i>italic</i>) хэлбэртэй бичиж, эшлэл авсан эх сурвалжийг бичнэ.
	Жишээ: <i>Дам эшлэв:</i> Ж.Авхиа, <i>Иргэдийн амь биеийн эсрэг гэмт хэргүүд, түүнтэй явуулах тэмцэл</i> , 1982, 200 дахь тал.
Эх сурвалжийн ижил хуудсыг дараалан эшлэх	Загвар: <i>Мөн тэнд</i> гэж налуу (<i>italic</i>) хэлбэртэй бичнэ.
	Жишээ: <i>Мөн тэнд.</i>
Өмнө дурдагдсан эх	Загвар: Зохиогчийн овог (бүтнээр). Нэр, <i>өмнөх эшлэл эшлэлийн дугаар</i> , эх

сурвалжийг дахин эшлэх	сурвалжийн хуудасны дугаар.
	<i>Жишээ:</i> Жарантайн Авхиа, өмнөх эшлэл 3, 15 дахь тал.
Хуулийн заалт	<i>Загвар:</i> Хуулийн нэр (батлагдсан он) зүйл заалтын дугаар “...” Хоёр дахь удаа эшлэх тохиолдолд хуулийн нэрийг товчилж бичнэ.
	<i>Жишээ:</i> <i>Эхний удаад эшлэх тохиолдолд:</i> Захиргааны ерөнхий хууль (2015)-ийн 35 дугаар зүйлийн 35.1 “...” <i>Хоёр дахь удаа эшлэх тохиолдолд:</i> ЗЕХ-ийн ...
ЗХХА-ын заалт	<i>Загвар:</i> Журмыг баталсан албан тушаалтан, батлагдсан он, журмын дугаар, Журмын нэр, зүйл заалтын дугаар “...”
	<i>Жишээ:</i> Засгийн газрын хэрэг эрхлэх газрын дарга, Сангийн сайдын хамтарсан 2014 оны 269/264 дүгээр тушаал, Улс хоорондын шуудангийн илгээмжийг гаалийн хилээр нэвтрүүлэх журмын 3 дугаар зүйлийн 1 дэх хэсэг “...”
Шүүхийн шийдвэр	<i>Загвар:</i> Шүүхийн нэр, он сар өдөр, шийдвэрийн дугаарыг өгүүлбэр хэлбэрээр бичнэ, шийдвэрийг үзэх холбоос. Хоёр дахь удаагаа эшлэх тохиолдолд шүүхийн нэрийг товчилж бичнэ.
	<i>Жишээ:</i> <i>Эхний удаа эшлэх тохиолдолд:</i> Улсын дээд шүүхийн 2023 оны 04 сарын 18-ны өдрийн 001/ХТ2023/00066 тогтоол, https://shuukh.mn/single_case/10200?daterange=2023/01 . <i>Хоёр дахь удаа эшлэх тохиолдолд:</i> УДШ-ийн 2023 оны 04 сарын 18-ны өдрийн ...

ХАВСРАЛТ 3. НОМ ЗҮЙ БИЧИХ ЖИШЭЭ

1. Монгол хэл дээрх эх сурвалж:

А. Эрх зүйн эх сурвалж

1. Аймаг, нийслэл, сум, дүүргийн иргэдийн төлөөлөгчдийн хурлын сонгуулийн тухай хууль, 2020 он.
2. Монгол Улсын Их Хурлын Сонгуулийн тухай хууль, 2019 он.
3. Улс төрийн намын тухай хууль, 2005 он.
4. Улсын дээд шүүхийн 2023 оны 04 сарын 18 өдрийн 001/ХТ2023/00066 тогтоол.

Б. Ном, сурах бичиг

1. Б.Амарсанаа, *Харьцуулсан эрх зүй судлал*, 2 дахь хэвлэл, 2014 он.
2. Д.Баярсайхан, *Эрх зүйн онол*, 2010 он.
3. Д.Гангабаатар, *Үндсэн хуулийн эрх зүй*, 2017 он.

В. Эрдэм шинжилгээний бүтээл

1. Ц.Цогт, “Монгол Улсын захиргааны хэргийн шүүхийн эрх зүйн орчин, дүн шинжилгээ”, *legaldata.mn*, 2023 он.
2. С.Бат-Орших, “Монгол Улс дахь шүүхийн жишиг”, *Монголын төр, эрх зүй сэтгүүл*, №1 (103), 2023 он.
3. Л.Заяа, “Хуулийн хэм хэмжээг тайлбарлан хэрэглэх, төсөөтэй хэрэглэх асуудал засаглалын хууль тогтоох ба шүүх эрх мэдлийн эмзэг зааг болох нь”, *Хууль дээдлэх ёс сэтгүүл*, №4, 2005 он.

Г. Бусад

1. Венецийн комисс, “Монгол Улсын улс төрийн намын тухай хуулийн төсөл, санал, дүгнэлт”, 2022 он.
2. Шилэн нам авлигын эсрэг түншлэл, “Улс төрийн санхүүжилтийн ил тод байдал, авлигын эрсдэлийн үнэлгээний тайлан”, 2018 он.

2. Гадаад хэл дээрх эх сурвалж:

- [А. Англи хэл дээр](#)
- [Б. Герман хэл дээр](#)
- [В. Орос хэл дээр](#)
- [Г. Солонгос хэл дээр](#)
- [Д.Хятад хэл дээр](#)
- [Е.Япон хэл дээр](#)

3. Цахим эх сурвалж

1. Монгол Улсын эрх зүйн мэдээллийн нэгдсэн систем: <https://legalinfo.mn/mn>.
2. Улсын Их Хурлын Тамгын газрын цахим хуудас: <https://www.parliament.mn/nn/17671/>.
3. Япон улсын төрийн албаны зөвлөлийн цахим хуудас: <https://www.iinji.go.jp>.

ХАВСРАЛТ 4. ГАДААД ЭХ СУРВАЛЖААС ЭШЛЭЛ ХИЙХ ЖИШЭЭ

1. АНГЛИ ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ¹

Ном	Эхний удаад эшлэх тохиолдолд: Nihal Jayawickrama, <i>The Judicial Application of Human Rights Law: National, Regional and international Jurisprudence</i>, 1st ed. (Cambridge University Press, 2003), 283-284. Хоёр дахь удаагаа эшлэх тохиолдолд: Ibid 478. Jayawickrama, <i>supra</i> note 5. 100.
Өгүүлэл	John D.Huber and Cecilia Martinez-Gallardo, “Replacing Cabinet Ministers: patterns of Ministerial Stability in Parliamentary Democracies” , <i>American Political Science Review</i> 102, no2 (May 2008), 169, jstor.mn
Хуулийн заалт	Constitution of Moldova (1994), art. 9(2). Administrative Procedure Act §76 “.....”
Шүүхийн шийдвэр	United States v. MacDonald, 531 F.2d 196, 199-200 (4th Cir. 1976). Meritor Sav. Bank v. Vinson, 477 U.S. 57, 60 (1986) .
Хурлын тэмдэглэл	Csaba nikolenyi, “The Impact of Government Formation rules in Four Post-Communist Democracies” (World Congress of the International political Science Association, Fukuoka, Japan, July 10, 2006),14, http://paperroom.ipsa.org/papers/paper_5077.pdf
Мэдээ	“Australian NSW Leader Resigns over Wine Gift” , BBC News Asia, April 16, 2014, http://www.bbc.com/news/world-asia-27045603
Олон улсын гэрээ	Article 28, Convention on the Rights of the Child (adopted 20 November 1989, entered into force 2 September 2000) UN Doc A/44/49 (1989) (CRC), https://www.ohchr.org/en/instruments-mechanisms/instruments/convention-rights-child
The International Court of Justice-ийн шийдвэр	Military and Paramilitary Activities (Nicar. v. U.S.), 1986 I.C.J.14, 181 (June 27), https://www.icj-cij.org/.
European Union Courts –ийн шийдвэр	Case T-198/98, Micro Leader Bus. v. Comm’n, 1999 E.C.R. II-3989, https://eur-lex.europa.eu/.

¹ Англи хэл дээрх эшлэл авах аргачлалыг хийхэд Токиогийн их сургуулийн Хууль зүйн сургуулийн бэлтгэсэн эшлэл хийх аргачлал буюу 東京大学法科大学院ローレビュー第 12 期編集委員会 「東京大学法科大学院ローレビューにおける文献の引用方法」 (2017 年) -ийг; О.Мөнхсайхан “Эшлэл хийх нь (Чикаго хэв маяг),” Хууль зүйн судалгаа, анализ, бичлэг хичээл, 2015, 1-2 дахь тал; АНУ-д хамгийн өргөн хэрэглэгддэг хууль зүйн эшлэлийн гарын авлага “The Bluebook” Nineteenth Edition дээрх жишээ 87-175 дугаар тал дахь зарим жишээнүүдийг тус тус ашигласан болно.

European Court of Human Rights-ийн шийдвэр	Papon v. France (No.2), 2001-XII Eur. Ct. H.R. 235, https://hudoc.echr.coe.int/.
Хууль тогтоомжийн төсөл боловсруулахад ашигласан материал а. Хуулийн төсөл b. Хууль тогтоох байгууллагын тогтоол с. Хорооны илтгэл d. Хууль тогтоох байгууллагын сонсгол e. Хууль тогтоох байгууллагын мэтгэлцээн	a. Privacy protection Act of 1998, H.R. 3224, 105th Cong.§ 2(a) (1998). H.R. 119, 54th Cong. (1st Sess. 1896) b. H.R.J.Res. 79, 106th Cong. (1999) c. H.R.Rep.No. 101-524, at 10 (1990), <i>reprinted in</i> 1990 U.S.C.C.A.N. 1448, 1451. d. <i>Background and History of Impeachment: Hearing Before the Subcomm. on the Constitution of the H.Comm on the Judiciary</i>, 105th Cong 22-23 (1998) (statement of Rep. Hutchinson, Member, H.Comm. on the Judiciary) e. 145 Cong. Rec. H1817 (daily ed.Apr.12, 1999) (statement of Rep.Pease). <i>Товчилсон дараах нэр томъёог тухайн улсын онцлогт тохируулан өөрчилж бичнэ:</i> H.R.Res-House Resolution H.R.J.Res-House Joint Resolution Cong-Congress
Захиргааны болон гүйцэтгэх байгууллагын дүрэм, журам а. Зохицуулалт b. Шийдвэр	a. FTC Credit Practices Rule, 16 C.F.R. §444.1 (1999) b. Reichhold Chems., Inc., 91 F.T.C.246 (1978). <i>Товчилсон дараах нэр томъёог тухайн улсын онцлогт тохируулан өөрчилж бичнэ:</i> FTC-Federal Trade Commission
Сонин, сэтгүүл	Ari L. Goldman, <i>O' Conner Warns Politicians Risk Excommunication over Abortion</i>, N.Y.Times, June 15, 1990, at A1. Barbara Ward, <i>Progress for a Small Planet</i>, Harv.Bus.Rev., Sept.-Oct.1979, at 89, 90.
Цахим эх сурвалж а. албан ёсны баримт бичиг b. хуулбарлах боломжгүй	a. Office of Mgmt. & Budget, <i>A New Era of Responsibility: Renewing America's Promise</i> (2009). b. Conference Report, German Soc'y for Contemporary Theatre and Drama in English, <i>Mediated Drama /Dramatized Media: From Boards to Screens to Cyberspace</i> (June 17-20, 1999), http://fb14.uni-

баримт бичиг с. зөвхөн цахимаар уншиж болох материал)	mainz.de/prospects/CDE/conf/1999/ . с. Ben & Jerry's Homemade Ice Cream, http://www.benjerry.com (last visited Oct.6, 2008)
Толь бичиг, нэвтэрхий толь	<i>Black's Law Dictionary</i> 562 (11th ed. 2019). 25 Am. Jur. 2d <i>Evidence</i> § 15 (2022).
Засгийн газрын тайлан	U.S. Gov't Accountability Off., <i>Climate Change: Information on Potential Economic Effects Could Help Guide Federal Efforts to Reduce Fiscal Exposure</i> , GAO-17-720 at 15 (2017).
Хурал, уулзалт дээрх илтгэл	Sandra Day O'Connor, <i>The Importance of Judicial Independence</i> , Keynote Address at the American Bar Association Annual Meeting, Chicago, Ill. (Aug. 5, 2006).

2. ОРОС ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ²

Ном	Антокольская М.В. Семейное право: Учебник. – М.: Юрист, 2017. – 336 с.
Өгүүлэл	Гараймович Д.А. Оценочные понятия в современном гражданском праве // Цивилистические записки: Межвузовский сборник научных трудов. – М.:Статут, 2001. – С. 144-153.
Хуулийн заалт	Ст. 3 Конституции РФ. Принята на всенар. голосовании 12 дек. 1993 г. // СЗ РФ. - 1994. - № 1. - Ст. 1. П. 1 ст. 2 Гражданского кодекса РФ. Часть 1 // СЗ РФ. -1994. - № 32. - Ст. 3301.
Шүүхийн шийдвэр	Решение Верховного Суда РФ от 8 апреля 2015г. № ВКГПИ15-9 //Неофиц. ист.: Справочно-правовая система «Консультант Плюс».

² Орос хэл дээр эшлэл авах аргачлалыг дараах эх сурвалжийг ашиглан боловсруулсан болно. Үүнд:

- Ростов Улсын Эдийн Засгийн Их Сургуулийн иргэний эрх зүйн тэнхимээс гаргасан “Эх сурвалж эшлэх жишээ” (2019). Дэлгэрэнгүй үзэх холбоос: [Образец оформления списка использованных источников, сносок, рисунков.pdf](#)
- Оросын Холбооны Улсын Хүмүүнлэгийн Ухааны Их Сургуулиас гаргасан “Эрдмийн ажилд эшлэл хийх удирдамж” (орос хэл дээр: Российский государственный гуманитарный университет) Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://clck.ru/3CkQMw>
- М.В. Ломоносовын нэрэмжит Москва Улсын Их Сургуулийн албан ёсны цахим хуудаст байршуулсан “Эх сурвалж эшлэх жишээ” (2024). Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://lomonosov-msu.ru/rus/event/9000/page/3879>
- Орос Стандартчиллын институтээс гаргасан “Цахим баримт бичиг эшлэх ерөнхий шаардлага” (2022). Дэлгэрэнгүй үзэх холбоос: https://library.altspu.ru/docs/gost_r_7.0.108-2022.pdf

Хурлын тэмдэглэл	Ткачев И.Ю. Семантический признак 'Накопитель эффекта' и его релевантность для построения таксономической классификации русских глаголов // Материалы XII Международной конференции студентов, аспирантов и молодых ученых «Ломоносов». 12-15 апреля 2005 г. Т.IV: Иностранные языки. Филология. М., 2005.
Мэдээ	Новости // ГИТИС : сайт. М., 2023. URL: https://gitis.net/press/news/ (дата обращения : 21.05.2024).
Олон улсын гэрээ	Европейская Конвенция о защите прав человека и основных свобод. Рим, 4 ноября 1950 г. // СЗ РФ. - 2001. - № 2. - Ст. 163. <i>Цахим эх сурвалжаас эшлэх жишээ:</i> Конвенция о правах ребенка: одобрена Генеральной Ассамблеей ООН 20.11.1989, вступила в силу для СССР 15.09.1990. Текст: электронный // Сборник международных договоров СССР. 1993. Вып. XLVI. URL: http://www.consultant.ru/document/cons_doc_LAW_9959 .

3. GERMAN ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ³

Ном	<i>Эхний удаад эшлэх тохиолдолд:</i> Schmidt, Bernd: Richtig zitieren: eine Anleitung für Studierende, 2. Aufl., Berlin, Deutschland: Springer, 2020, S. 117. <i>Хоёр дахь удаад эшлэх тохиолдолд:</i> Schmidt, 2020, S. 117.
Өгүүлэл	Elsen, Hilke: Neologismen in der Jugendsprache, in: Muttersprache: Vierteljahrsschrift für deutsche Sprache, Bd. 112, Nr. 2, 2002, doi:10.5282/ubm/epub.14557, S. 140.
Хуулийн заалт	§ 81 Absatz 1 Satz 2 BGB § 81 Abs. 1 S. 2 BGB
Шүүхийн шийдвэр	OLG Hamburg, 4. November 2013, Az. XI Z 243/13
Сонины мэдээ	Rodemann, Julian: Chemie-Nobelpreis geht an zwei Genforscherinnen, in: Süddeutsche Zeitung, 07.10.2020, https://www.sueddeutsche.de/wissen/nobelpreis-2020-chemie-1.5057356 (abgerufen am 05.11.2020).

³ Герман хэл дээр эшлэл хийх аргачлалыг дараах эх сурвалжийг ашиглан боловсруулсан болно.
Үүнд:

- [Gesetze zitieren - Anleitung für deine Abschlussarbeit \(scribbr.de\)](https://scribbr.de/Gesetze-zitieren-Anleitung-fuer-deine-Abschlussarbeit)
- Олон Улсын эрх зүйн баримт бичгийг эшлэх аргачлалыг Мюнстэр их сургуулийн цахим хуудаснаас. Дэлгэрэнгүй үзэх холбоос: https://damjura.uni-muenster.de/razuna/assets/2/D1C7480D4CFC42169263426F35C93EF5/doc/69BBB62B535D48E9BC14B1A115010542/Internationale_Dokumente_zitieren.pdf

Олон улсын гэрээ	Art. 121 AEUV
	<i>Хүчингүй болсон заалт эшлэх загвар:</i> Зүйл, хэсэг, баримт бичгийн товчлол, (Vertrag über die Europäische Union), хаалтад а.Ф тэмдэглэгээ тавих.
	Art. 6 EUV (ex-Artikel 6 EUV a.F.)
Дүрэм, удирдамж	Verordnung (EG) Nr. 338/97 – Schutz von Exemplaren wildlebender Tier- und Pflanzenarten durch Überwachung des Handels
Европын Холбооны хүний эрхийн шүүхийн шийдвэр	EuGH, Urt. v. 9.12.1997, Rs. C-265/95, ECLI:EU:C:1997:595, Rn. 86
Хуулийн төслийн хэлэлцүүлгийн тэмдэглэл	Gesetzentwurf der Bundesregierung, Entwurf eines Gesetzes zur Modernisierung des Bilanzrechts (Bilanzrechtsmodernisierungsgesetz – BilMoG), in: Bundestagsdrucksache Nr. 16/10067.
Цахим эх сурвалж	Erichsen, Cornelia/Dunya Hayali/Raul Mutig: Inklusion im Internet: So werden Social-Media-Inhalte barrierefrei, in: t3n, 2020, https://t3n.de/magazin/inklusion-im-internet-so-werden-249553/ (abgerufen am 05.11.2020).

4. ФРАНЦ ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ⁴

Ном	Carley, Michael J. <i>L'Alliance de la Dernière Chance : Une Réinterprétation des Origines de la Seconde Guerre Mondiale</i> . Montréal : Les Presses de l'Université de Montréal, 2001.
Өгүүлэл	Vibert, Sarah. « Anorexie Mentale et Fonctionnements Limite. Traitement Diversifié de la Perte et du Conflit Oedipien à l'Adolescence. » <i>Évolution Psychiatrique</i> 76.1 (2011) : 55-74. <i>Scholar's Portal</i> . Web. Le
Хуулийн заалт	Loi n°67-1176 du 28 décembre 1967 relative à la régulation des naissances (J.O. 29 décembre 1967).
Шүүхийн шийдвэр	CE, 27 décembre 1947, Rec. CE, p.498.
Хурлын тэмдэглэл	Le droit de l'Union européenne et le droit français, Université de Poitiers et la Faculté de Droit et Sciences sociales, Mars 2022.
Хурлын эмхэтгэл	Chargee De Reglementer Diverses Matieres De Droit International Prive, Les conférences internationales de La Haye, La Haye, Septembre 1893, Vol. 1, p 24.

⁴ Франц хэл дээр эшлэл хийх аргачлалыг дараах эх сурвалжийг ашиглан боловсруулсан болно. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://biblio.laurentian.ca/research/fr/guides/citer-ses-sources>

Мэдээ	Thomas E. Carbonneau. " Étude historique et comparée de l'arbitrage. Vers un droit matériel de l'arbitrage commercial international fondé sur la motivation des sentences". Revue internationale de droit comparé Magazine, Vol. 36 N°4, Octobre-décembre 1984, pp. 727-781. Société de législation comparée, https://www.unipresse.com/subscription/revue-internationale-de-droit-compare/ .
Олон улсын гэрээ	La Déclaration universelle des droits de l'homme, 1948, Assemblée générale des Nations unies

5. ЯПОН ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ⁵

Ном	<i>Эхний удаа эшлэх тохиолдолд:</i> 宇賀克也『行政法概説 I（第7版）』（有斐閣・2020年）503頁。 <i>Хоёр дахь удаа эшлэх тохиолдолд:</i> 玉蟲・前掲注（37）222頁。 <i>Олон зохиогчтой тохиолдолд:</i> Н・ミッタイス＝Н・リーベリッヒ（世良晃志郎訳）『ドイツ法制史概説（改訂版）』391頁（創文社・1971年）。
Өгүүлэл	玉蟲由樹「人間の尊厳の客観法的保護」福岡大学法学論集51巻4号（2008年）169頁。
Хуулийн заалт	行政手続法(1994年)4条「……」。
Шүүхийн шийдвэр (сэтгүүлд нийтлэгдээгүй)	大阪地判平成23年10月25日（LEX／DB文献番号25443936）。
Шүүхийн шийдвэр (сэтгүүлд нийтлэгдсэн)	大阪地裁平成20年1月31日判決判例タイムズ1268号152頁。
Илтгэл болон хуралдааны үеэр хэлсэн үг	小川秀樹ほか「新破産法と否認の実務（中）」金法 1730 号 20 頁〔田原睦夫発言〕（2005年）。
Мэдээ	「△社の○○を発表」朝日新聞朝刊東京本社版2007年10月5日，5面。

⁵ Япон хэл дээр эшлэл хийх аргачлалыг Токиогийн их сургуулийн Хууль зүйн сургуулиас гаргасан эшлэл хийх “東京大学法科大学院ローレビュー第12期編集委員会「東京大学法科大学院ローレビューにおける文献の引用方法」（2017年）” аргачлалыг ашиглан боловсруулсан болно.

Цахим эх сурвалж	金融庁「空売り規制・自己株式取得に係る時限措置の延長に関する内閣府令・告示の公布 について」2011 年 10 月 31 (http://www.fsa.go.jp/news/23/syouken/20111031-2.html, 2011 年 12 月 1 日最終閲覧)。
------------------	---

6. ХЯТАД ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ⁶

Ном	刘国钧,陈绍业.图书目录[M].北京:高等教育出版社,1957:15-18.
Өгүүлэл	何龄修.读南明史[J].中国史研究,1998(3):167-173.
Хуулийн заалт	《刑法》第XX条 XX项XX款规定
Шүүхийн шийдвэр	王某某, 8000500056565, https://www.court.gov.cn/zixun-xiangqing-286491.htm (Сүүлд үзсэн: 2020.01.20)
Хурлын тэмдэглэл	第八届中日刑事法研讨会, 众济律师事务所, 昆明, 2024 “西原春夫先生与中日刑事法交流”高桥则。
Мэдээ	谢希德.创造学习的新思路[N].人民日报,1998-12-25(10).
Олон улсын гэрээ	《联合国反腐败公约》第3条。
Цахим эх сурвалж	王明亮.关于 中国学术期刊 标准化数据库系统工程的进展[EB/OL].1998-08-16/1998-10-01.

7. СОЛОНГОС ХЭЛ ДЭЭРХ ЭШЛЭЛ⁷

Ном	정웅석·백승민, 형사소송법(전정제5판), 대명출판사 (2012), 77.
Өгүүлэл	이창희, “세법상 속인주의와 속지주의의 대립”, 서울대학교 법학 제50권 제1호(2009. 3.), 237.
Хуулийн заалт	장사 등에 관한 법률 시행령 제18조 제1항.
Шүүхийн шийдвэр	대법원 1992. 5. 26. 선고 92다84 판결.

⁶ Хятад хэл дээр эшлэл хийх аргачлалыг БНХАУ-ын Бээжингийн их сургуулийн магистрын диссертаци бичих удирдамжийг ашиглаж боловсруулсан болно. Дэлгэрэнгүй үзэх холбоос: https://mba.phbs.pku.edu.cn/2015/guide_1030/612, <https://baike.baidu.com/item/%E5%8F%82%E8%80%83%E6%96%87%E7%8C%AE%E6%A0%87%E5%87%86%E6%A0%BC%E5%BC%8F/15571284>

Тус улсын GB3569-83 дугаар “эх сурвалжийн төрлийг орлох тэмдэг”-ийг анхаарах нь чухал. Тухайлбал, [M]- ном, [J]- сэтгүүл, [N]-сонин, мэдээ, [D]-дипломын ажил, [R]- судалгааны тайлан гэх мэт төлөөлөх тэмдгийг анхаарах ёстой.

⁷ Солонгос хэл дээр эшлэл хийх аргачлалыг БНСУ-ын Дээд шүүхийн “Шүүхийн бодлого судалгааны хүрээлэн”-ээс 2017 онд гаргасан “Хууль зүйн бүтээлд эшлэл авах тухай жишиг төсөл”-өөс эшилсэн болно. Дэлгэрэнгүй үзэх холбоос: <https://jpri.scourt.go.kr/fileDownload.do?seq=746>

Хурлын тэмдэглэл	이광수, “법조일원화체제 하에서의 바람직한 법관임용방안”, 새로운 법조환경에서 바람직한 법관임용방안 모색을 위한 심포지엄, 사법정책연구원 (2014. 7. 1. 발표), 21.
Мэдээ	전경배, “기고-상고법원 역할 늘려 대법원 부담 줄이자”, 동아일보 (2014. 8. 28.), A33.
Дипломын ажил	김형근, “언론의 인격권 침해에 대한 사법상 구제”, 석사학위 논문, 서울대학교 (2008), 15.
Цахим эх сурвалж	김두얼, “사법정책과 경제성장”, 한국경제포럼 제5권 제1호 (2012), 74, http://www.kea.ne.kr/upload/catalogue_file/aaeec8f6224e1769b8a46ed51677d939.pdf (2014. 8. 25. 확인).

---o0o---